

Төрийн бус байгууллагуудын (ТББ) чадавхийг бэхжүүлэх

Гүйцэтгэгч: Ардчиллын Боловсрол Төв
Судалгаа хийгдсэн он: 2003

Уг судалгааг ТББ-уудад одоогийн байдлаар нэн шаардлагатай байгаа үйлчилгээг тандаж мэдэх зорилгоор 2003 оны 8-9-р сард Ардчиллын Боловсрол Төвөөс “ТББ-ын чадавхийг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд хийсэн юм.

Уг судалгаанд орон нутгийн болон Улаанбаатар хотын 82 ТББ хамрагдав.

ТББ-ын хүсэн хүлээж буй болон нэн шаардлагатай байгаа үйлчилгээнүүд

№	Хүсэн хүлээж буй үйлчилгээний төрлүүд	Хувь (100%)
1	Сургалтын тухай мэдээлэл, сургалтанд хамрагдах, сургалт явуулдаг байгууллагуудын талаарх мэдээлэл	22,5%
2	ТББ-ын байршил, хаяг, холбооны талаар мэдээлэл	21,4%
3	Хуулийн зөвлөгөө, үйлчилгээ авах	19,5%
4	ТББ-ын үйл ажиллагаагаа бэхжүүлэх, туршлага судлах, төсөл бичих	14,1%
5	Техник үйлчилгээ (интернетээс мэдээлэл авах, бичиг баримт олшруулах, утсаар ярих, г.м).	10,1%
6	Донор байгууллагуудын тухай мэдээлэл	6,5%
7	ТББ, иргэний нийгмийн талаарх эх сурвалж, материал, судалгаа	5,9%

- Тус судалгаанд хамрагдагсдын 22,5% нь Байгууллагын чадавхийг бэхжүүлэх чиглэлийн сургалтууд болон сургалт авах талаар хэрэгцээ шаардлага байгаагаа илэрхийлсэн бол, 21,4% нь ТББ-ын байршил, хаяг, холбооны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах нь нэн хэрэгцээтэй байгаа талаар хүсэлтээ гаргасан байна.
- Мөн 19,5% нь ТББ-ын тухай хуулийн зөвлөгөөг ТББ-уудад нэн хэрэгцээтэй мэдээлэл гэж үзэж, энэ тал дээр ойлгомжтой гарын авлага, товхимол эрэлт хэрэгцээтэй байгааг илэрхийлсэн байна. ТББ-ын ажилтнууд АБТ-өөс ТББ-ын бүртгэл, татвар болон гэрээгээр ажил гүйцэтгэх, дотоод менежментийн асуудал, ТББ-ын бичиг баримтыг хэрхэн хуулийн дагуу хөтлөх, боловсруулах, тайлан гаргах талаарх зөвлөгөө/үйлчилгээг хүсч байна.
- ТББ-уудын тулгамдсан гол асуудал нь санхүүжилт байдаг бөгөөд АБТ “Төсөл хэрхэн бичих” сэдвээр сургалт явуулахаас гадна төсөл бичих, боловсруулах үйлчилгээнд зөвлөгөө өгдөг. ТББ-ын ажилтнуудын 14,1% нь байгууллагынхаа санхүүгийн чадавхийг сайжруулах, эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд төсөл бичих чадварт суралцах хүсэл эрмэлзэлтэй байдаг нь манай байгууллагын явуулсан санал асуулгаас ажиглагдаж байна.
- Мөн АБТ-өөр үйлчлүүлэгчдэд мэдээллийг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэхийн тулд техник үйлчилгээг (эх сурвалжийг хэвлэж, олшруулж өгөх, мэдээллийг интернетээс хайх, ТББ-уудын хооронд утсан харилцаагаар зуучлах, утсаар яриулах зэрэг компьютер, канон, скайнер, дижитал аппарат, утас, ном үдэх машин г.м тоног төхөөрөмж) нэн шаардлагатай гэж үзжээ. Бид тухайн үйлчилгээг үзүүлэхэд тусгай тэмдэглэл хөтөлдөг бөгөөд 2003 оны байдлаар 1500 гаруй А4 цаасны багтаамж бүхий мэдээллийг олшруулж, хэвлэж өгсөн байна. Дээрх үйлчилгээний бүртгэлээс харахад ихэнх ТББ-уудын чадавхи сул, өөрийн гэсэн ажлын байргүй, техник хэрэгслийн дутагдалтай байдал нь ТББ-уудад үйл ажиллагаагаа явуулахад гол саад бэрхшээл болдог байна. ТББ-ын 10,1% нь ямар нэг байдлаар техникийн туслалцаанд хамрагдахыг хүсч байгаагаа илэрхийлжээ.

Дүгнэлт:

Уг судалгаанаас үзэхэд өнөөгийн ТББ-уудын чадавхийг бэхжүүлэхэд нэн шаардлагатай байгаа сургалт, зөвлөгөө, техникийн туслалцаа зэрэг үйлчилгээнүүдийг тухайн ТББ-уудын үйл ажиллагааны чиглэл болон хүсэн хүлээж буй эрэлт хэрэгцээн дээр тулгуурлан тодорхой хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ардчиллын Боловсрол Төв (АБТ) нь сайн дурын, ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм. АБТ нь “**Ардчиллын Боловсрол**”, “**ТББ-ын чадавхийг бэхжүүлэх**” гэсэн үйл ажиллагааны үндсэн хоёр хөтөлбөртэй.

Манай хаяг: **УБ хот, I-40.000, 52-р байр (ОХУ-ын ЭСЯ-ны баруун талын орон сууц)**

Утас/факс: **310560**

И-мэйл: demo@magicnet.mn